



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/108

Улаанбаатар хот

┌ Хуралд оролцуулах тухай ─┐

Тус хорооны Дүрмийн 3.1.2, 3.1.10 дахь хэсэг, Хөдөлмөрийн дотоод журмын 2.6.1, Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны томилолтоор ажиллах журмын 2.1, 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. Америкийн Нэгдсэн Улсын Лас Вегас хотод зохион байгуулах "NAV-Өргөн нэвтрүүлгийн үндэсний холбооны 2022 оны хурал"-д Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газрын дарга А. Лувсан-Очирыг 2022 оны 04 дүгээр сарын 23-аас 27-ны өдрүүдэд оролцуулсугай.
2. Хурал, үзэсгэлэнд оролцох удирдамжийг нэгдүгээр, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Шаардагдах зардлын төсвийг холбогдох эх үүсвэрээс олгохыг Санхүүгийн хэлтсийн дарга /Н.Халиунаа/-д зөвшөөрсүгэй.
4. Хурал, үзэсгэлэнд оролцсон тайланг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газарт, холбогдох тооцоог санхүүгийн хэлтэст тайлагнахыг А. Лувсан-Очирт үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ


Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны
даргын 2022 оны 04 сарын 07 өдрийн
А/108 тушаалын нэгдүгээр хавсралт

АНУ-ын Лас Вегас хотноо зохион байгуулагдах
NAB – Өргөн нэвтрүүлгийн үндэсний холбооны 2022 оны
хурал, үзэсгэлэнд оролцох удирдамж

Өргөн нэвтрүүлгийн бүтээл үйлдвэрлэлтэй холбоотой туршлага солилцох, хуваалцах болон хэвлэл мэдээллийн салбарын менежментийн загваруудыг судлах, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний болон контент хөгжүүлэлтийн платформ шийдэл, технологийн хөгжүүлэлттэй танилцахтай холбоотойгоор Өргөн нэвтрүүлгийн үндэсний холбооны 2022 оны хурал, үзэсгэлэн АНУ-ын Лас Вегас хотноо зохион байгуулагдана. Энэхүү хурал, үзэсгэлэнд тус хорооны Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газрын дарга А.Лувсан-Очир дараах чиглэлийг баримтлан оролцоно. Үүнд:

1. Оролцогчдод зориулсан кино үйлдвэрлэл болон алсын зайн, виртуал орчинд контент үйлдвэрлэлтэй холбоотой сэдвүүдийн хүрээнд практик туршлага судлах интерактив семинаруудад оролцох;
2. Үзэсгэлэнгийн хүрээнд контентийг бүтээх, түгээх, зах зээлд гаргахтай холбоотой бизнесийн болон технологийн шийдэл, платформын талаар танилцах, тэр дундаа контент түгээх платформууд (*глобал мобайл платформ, OTT, IoT, AI ...*)-ын танилцуулга, боломжуудыг судлах;
3. Медиа экосистем дэх хувьсал, медиа салбарын өрсөлдөөн, медиа салбарт ашиглагдаж буй дэвшилтэд технологийн боломжууд, эдгээр хэрхэн дасан зохицох, нийцэх тухай;
4. Медиа салбарын өөрчлөлт, өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг дагаад амжилттай брэнд, байгууллага, компаниуд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, туршлагыг хэрхэн бий болгож байгааг тухай, ирээдүйд юу хүлээж байгаа талаар;
5. NAB Show Conference хүрээнд Broadcast Engineering & IT Conference (BEITC) хэсэгт зохион байгуулагдах өргөн нэвтрүүлгийн тоног төхөөрөмж үйлдвэрлэгчид, дистрибьютерүүд, инженерийн зөвлөхүүд болон R&D инженерүүдэд зориулагдсан хөтөлбөр хамрагдах (хөтөлбөрт мониторинг хийх, хөтөлбөр архивлах, технологийн дэвшил, IT-д суурилсан системийн шилжилт, хиймэл оюун ухаан гэх мэт);

Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны
даргын 2022 оны 04 сарын 07 өдрийн
А/108. тушаалын хоёрдугаар хавсралт



Үзэсгэлэн, хуралд оролцох зардлын төсөв

2022.04.23-2022.04.27

№	Зардлын утга	Төсөвлөсөн (ам.доллар/төгрөг)	Тайлбар
1	Зам хоног	US\$60*8 хоног) *1 хүн = \$480	
2	Зочид буудал	(US\$200*7 хоног)*1 хүн =\$1400	
3	Тийз	₮5,150,000*1=₮5,150,000	
4	Визний хураамж	\$160*1=\$160	
5	Арга хэмжээнд оролцох тасалбар	\$699*1хүн=\$699	
6	Нийт дүн:	\$2,739 ₮5,150,000	